

“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 12/24

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь заалт, 61 дугаар зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, компанийн 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, “Булигаар” ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1. Булигаар ХК-ийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг зээлийн гэрээний барьцаанд тавих эрх олгох тухай;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2024 оны 06 дугаар сарын 10, 25-ны өдрүүдэд өдөр тутмын сониноор тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг Хавсралт №2-оор баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2024 оны 7 дугаар сарын 19-ний 14.00 цаг хүртэл байна.
6. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1,

Хавсралт №2 дахь мэдээлэл болон компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт тус тус хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичгийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
8. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар А.Энхмэндийг, мөн хурал зохион байгуулах комиссын даргаар Ц.Мөнхлхагва, гишүүдэд Н.Тэмүүжин, С.Аззаяа нарыг сонгосугай.
9. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилон байгуулсугай.
Тооллогын комиссын дарга: Г.Анужин
Тооллогын комиссын гишүүд: Д.Энхзул, Ю.Дүгэрмаа
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материал, баримт бичигтэй ажлын өдрийн 09:00-17:00 цагийн хооронд хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг бүрдүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичиг С.Аззаяад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
12/24 тоот тогтоолын Хавсралт 1



ХУРЛЫН ЗАР

“БУЛИГААР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 07 дүгээр сарын 19-ний өдрийн 14:00 цагт “Булигаар” ХК-ийн байранд болох тул хувьцаа эзэмшигчдийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

- Булигаар ХК-ийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг зээлийн гэрээний барьцаанд тавих эрх олгох тухай;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2024 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд компанийн өөрийн байранд хурал зохион байгуулах комиссын гишүүд нараас холбогдох мэдээллийг авч танилцах боломжтой.

Холбоо барих утас: 99190037, 99050358, 88324642

И-мэйл хаяг: info@buligaar.com

“Булигаар” ХК-ийн албан ёсны хаяг, байршил:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо,
Арьс ширний үйлдвэрийн хашаа, өөрийн байр.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
12/24 тоот тогтоолын Хавсралт 2

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн ОВОГ..... нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Хурал хуралдах газар, өдөр: **Булигаар ХК-ийн хурлын танхимд**
/УБ хот, ХУД, 20-р хороо, компанийн 2-р давхарт/
2024 оны 07 дугаар сарын 19-ны өдөр, 14:00 цагт

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-ын хүрээнд санал хураах арга: **Энгийн**

№	Батлах асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Булигаар ХК-ийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг зээлийн гэрээний барьцаанд тавих эрх олгох тухай;			
Заавар: Та өөрийн саналыг (“√ “болон “+”) тэмдгээр тэмдэглэнэ. Засварласан болон балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.				

Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг	
Овог нэр:	
Гарын үсэг:	
Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг	
Хуулийн этгээдийн нэр:	
Улсын бүртгэлийн дугаар:	
Хувьцаа эзэмшигч хувь хүн болон хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бөглөх хэсэг	
Овог нэр:	
Гарын үсэг:	

2024 оны -р сарын -ны өдөр